



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/246

Арвайхээр сум

**Тендерийн гүйцэтгэгчийг сонгох,
тендер хүчингүй болгож, шууд гэрээ
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 34 дүгээр зүйлийн 34.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 27 дугаар зөвлөмжийн дагуу Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд 2023 онд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх тендерийн 4 дүгээр багц Сийвэн орлох, дуслaar хэрэглэх болон цусанд нөлөөлөх бэлдмэлүүдийг 186,117,000 (нэг зуун наян зургаан сая нэг зуун арван долоо) төгрөгөөр Айвико хэлт кейр ХХК-иар, 8 дугаар багц Арьсны өвчин болон мөөгөнцрийн эсрэг бэлдмэлүүдийг 38,142,000 (гучин найман сая нэг зуун дөчин хоёр мянга) төгрөгөөр Монфа трейд ХХК-иар, 14 дүгээр багц Зүү тариурыг 83,772,000 (наян гурван сая долоон зуун далан хоёр мянга) төгрөгөөр Мөнхийн тун ХХК-иар, 17 дугаар багц Мэс заслын утас зүүг 85,810,524 (наян таван сая найман зуун арван мянга таван зуун хорин дөрөв), 19 дүгээр багц Нэг удаагийн эмнэлгийн хэрэгслийг 53,963,940 (тавин гурван сая есөн зуун жаран гурван мянга есөн зуун дөч), 53 дугаар багц Уян зүү, зүүний нэг удаагийн хэрэгслийг 48,961,620 (дөчин найман сая есөн зуун жаран нэгэн мянга зургаан зуун хорь) төгрөгөөр тус тус Сүвэн-Уул ХХК-иар, 52 дугаар багц Дуслын системийг 49,392,000 (дөчин есөн сая гурван зуун ерэн хоёр мянга) төгрөгөөр Чодбацо ХХК-иар гүйцэтгүүлсүгэй.

2. Дээрх шалгарсан багцуудад гэрээ байгуулж, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авч, гэрээний хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв (Г.Дашжанцан)-д зөвшөөрсүгэй.

3. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн бараа нийлүүлэлтийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, гарсан зөрчлийг тухай бүр арилгаж тайланг нэгтгэн танилцуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т даалгасугай.

4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3.шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн

6223 11 0461

D:My Doc. Zahiramj. Zasag darga

болон оролцогч ороогүй 3 дугаар багц Сэтгэц нөлөөт болон уналт таталт, салга өвчнийг намдаах бэлдмэлүүд, 18 дугаар багц Төрөх нярайн эмнэлгийн хэрэгсэл, 22 дугаар багц Анестезлогийн хэрэгсэл, 23 дугаар багц Рентгений хэрэгсэл, 25 дугаар багц Цусны банк, 26 дугаар багц Гистологи- цитологийн урвалж, 27 дугаар багц Клиник лабораторийн урвалж (Альфа-Швед лаб), 32 дугаар багц Нян судлалын урвалж, 33 дугаар багц Нян судлалын бүрэн автомат анализаторын урвалж, 34 дүгээр багц Вирослогийн урвалж оношлуур, 36 дугаар багц Цусны хийн болон химийн анализатор (хүчил шүлтийн тэнцвэр), 38 дугаар багц Чих хамар хоолойн эм, эмнэлгийн хэрэгсэл, 39 дүгээр багц Нүдний болрын хагалгааны хэрэгсэл, 41 дүгээр багц Тан, 48 дугаар багц Ангиографийн хэрэгсэл (мэдрэл оношилгоо), 49 дүгээр багц Уралогийн дурангийн хэрэгсэл, 50 дугаар багц Ходоодны дурангийн ариутгалын бодис, 51 дүгээр багц Ходоодны дурангийн нэг удаагийн хэрэгсэл, 54 дүгээр багц Нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл багцуудыг тус тус хүчингүй болгож, шууд гэрээ байгуулсугай.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН